



**УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар #123

Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар театрын албан хаагчдын дагаж мөрдөх Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Дүрмийг албан хаагчдад танилцуулах, сургалт зохион байгуулж ажиллахыг Тайз үйлдвэрлэлийн ангийн дарга /Б.Түмэндэлгэр/, Хүний нөөцийн менежер /Л.Одгэрэл/ нарт тус тус даалгасугай.

3. Дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Л.Одгэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА



*[Handwritten signature]*

Р.МӨНХСАЙХАН

D:\2022\secretary\dargiin tushaal A4\  
31406000-1

Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын Даргын  
2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн  
А/23 дугаар тушаалын хавсралт

**“УЛААНБААТАР” ТЕАТРЫН АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Энэ дүрмийн зорилт нь Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж хэрэгжүүлэхэд оршино.
2. Дүрмээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи байгууллагын үндсэн зарчмыг тодорхойлж, байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
3. Улаанбаатар театрт ажилладаг нийт албан хаагчид болон театрын байранд үйл ажиллагаа зохион байгуулахаар ирсэн гадны байгууллагын албан хаагчид энэ дүрмийг биелүүлж мөрдлөг болгон ажиллана, дүрмийн шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй.

**Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

Энэ хуулийн 3 дугаар зүйлд дараах нэр томъёог дор дурдсан утгаар тодорхойлсон болно. хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно

- “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг;
- “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;
- “хөдөлмөрийн эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;
- “хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;
- “үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл” гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;
- “үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл” гэж ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг;
- “ажлын байран дахь эрсдэл” гэж иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцлийг;
- “эрсдэлийн үнэлгээ” гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг;
- “ажлын байр” гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;
- “хурц хордлого” гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;

- “тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг;
- “нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;
- “хамтын хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хоёр ба түүнээс дээш тооны ажилтныг нэгэн зэрэг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;
- “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг;
- “ажлын байр” гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсэн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө тасалгааг;
- “үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах” гэж гүйцэтгэж буй ажлын аюултай, хортой, хүнд, ачаалалтай байдал нь хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн хэм хэмжээнд нийцэж байгаад үнэлгээ өгөхийг;
- “хөдөлмөрийн аюулгүй нөхцөл” гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг;
- “үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал” гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;
- “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэж хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг.
- “үйлдвэрлэлийн осол” гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг;
- “үйлдвэрлэлийн орчин” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талбай, гадна орчныг;
- “эрсдэлийн түвшин их ажлын байр” гэж хөдөлмөрлөх явцад ажилтанд учирч болзошгүй аюултай хүчин зүйлийн магадлал нь зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байхыг.

#### **Гурав. Зааварчилгаа ба сургалт**

1. Тус театрын албан хаагчид болон үйл ажиллагаа зохион байгуулагчид нь энэхүү дүрмийн талаар зааварчилгаа авсан байна. Тэднийг гарч болзошгүй ослоос урьдчилан өөрийгөө болон нөхдийгөө хамгаалах арга ажиллагаанд сургасан байвал зохино.
2. Ерөнхий найруулагч, ангийн дарга нар болон тайз үйлдвэрлэлийн ангийн дарга, маркетингийн менежер, уран бүтээлийн ахлагч нь хаана ч байсан тоглолт, сургуулилтын өмнө зааварчилгааг өгч аюулгүй байдлын арга ажиллагаа зөрчигдсөн тухай бүр нийт бүрэлдэхүүнд зааварчилгаа өгч ажиллана.
3. Зааварчилгаа өгөх, аюулгүй ажиллагааны арга барилыг эзэмшүүлэх асуудлыг нэгж тус бүрийн ахлагч нар хариуцна.

#### **Дөрөв. Ерөнхий найруулагч, тайзны үйлдвэрлэлийн ангийн дарга нарын үүрэг**

1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллах арга техник, үйлдвэрийн ариун цэврийн талаар зохиогдож байгаа ажлын биелэлтийг шалгаж хангаж байх,

2. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөр хамгааллын дүрэм, заавар, түүнд холбогдох тогтоол шийдвэрийг анги, нэгжүүд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гүйцэтгэлийг шалгаж дүгнэх, удирдлагад тайлагнах,
3. Театрын байрны аппаратур, хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл зэргийг тогтмол шалгаж илэрсэн дутагдлыг яаралтай арилгах ажлыг зохион байгуулж гүйцэтгэх,
4. Театрын аппарат хэрэгслийн хийц, хэсэг, эд анги, паспорттой тохирч байгаа эсэхийг хянах,
5. Ажиллаж байгаа хүмүүсийн амь насанд аюултай гэж үзсэн тохиолдолд, мөн ажлын байрны хэсэгт шатаж тэсрэх бодис, материал байгаа үед үйл ажиллагааг зогсоож энэ тухай уран сайхны удирдаач буюу театрын даргад мэдэгдэх,
6. Ашиглалтанд үл нийцэх техник төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглалтаас хасах саналаа удирдлагад тавьж арга хэмжээ авахуулах,
7. Тоглолтын үед тайз, үзэгчид, гэрэл техникийн болон үйлчилгээний ажилчдын аюулгүй арга ажиллагааг удирдан зохион байгуулах,
8. Тоног төхөөрөмж, аппаратурын байрлалыг зохицуулан зөв байрлуулах,
9. Өвчтэй, эрүүл бус болон бусад шалтгаантай хүмүүсийг сургууль, тоглолтонд оруулахгүй байх,
10. Жижүүрийн гэрлийг тогтмол шалгах,
11. Тоглолтонд зөвхөн батлагдсан номер, уран бүтээлчдийг оролцуулах ба бусад хүмүүсийг сольж тоглохыг хориглох, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, аппарат хэрэгсэл шинэчлэх, 1 сараас дээш хугацаагаар завсардсан нөхцөлд давтан зааварчилгааг ахлагч нар хийх,
12. Тайз болон ажлын байранд харьяалалгүй хүмүүсийг хяналтгүй оруулахгүй байх, тайзан дээр тайзны ажилтан байхгүй үед болон тайз хариуцсан маркетингийн менежер, ерөнхий найруулагчийн зөвшөөрөлгүйгээр дасгал сургуулилт, зураг авалт хийх, үйл ажиллагаа явуулахгүй байхад хяналт тавих,
13. Албан хаагчид болон ахлагч нар өрөө тасалгаа, ажлын байр, аваарийн гарц, аппарат тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цоож түгжээний найдвартай байдалд онцгой анхаарч байх
14. Аюулгүй ажиллах арга техник, ариун цэврийн дүрэм зөрчсөн хүмүүст арга хэмжээ авах санал удирдлагад тавих, ажиллуулахыг зогсооно.

#### **Тав. Албан хаагчдын үүрэг**

1. Албан хаагчид, уран бүтээлчид, үйлчилгээний ажилчид нь үзэгчдийн аюулгүй ажиллагаа хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахын зэрэгцээгээр хөгжим хэрэгсэл, техник аппаратур, бусад ажлын хувцас, багаж хэрэгслээ ашиглах, байршуулах, зүүж бэхлэхэд болон дасгал сургуулилт, тоглолтын үед өөрийн аюулгүй байдлыг хангаж аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн байдалд хяналт,
2. Тоглолтын хувцас, хэрэгслийн ашиглалтын байдалд хяналт тавих,
3. Дасгал сургуулилтын болон ажлын цагийн хуваарийн мөрдөлтөнд хяналт тавьж, биеийн халаалт, дасгал хийгээгүй буюу эрүүл мэнд, сэтгэл зүйн доголдолтой байгаа буюу тоног төхөөрөмж, аппаратур, хөгжим, хэрэгсэл, хувцаслалт нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй албан хаагчийг ажиллуулах, тоглолт сургуулилтанд оруулахгүй байх,
4. Ажлын байрны зохион байгуулалт, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг зөрчих үйлдэл хийх, согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, ил гал гаргах, унтах, ажилд хамааралгүй хүн байлгах, ноцолдох, тоглох зэрэг үйлдлийг гаргахгүй байна.
5. Өөрийн ажлыг гадны болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, ажил удирдагчаас зөвшөөрч томилоогүй хүнээр хийж гүйцэтгүүлэхийг хориглоно.

- 6. Албан хаагчид нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажлыг гүйцэтгэхээс гадна удирдлагаас даалгасан ажил үүргийг гүйцэтгэнэ. Удирдлагын заавраар аливаа ажлыг гүйцэтгэхдээ уг ажлыг өмнө хийж гүйцэтгэж байгаагүй бол тухайн ажлын байрны заавар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг судалж мэдсэн байна.
- 7. Үзвэрийн танхимд болон бусад талбай дахь шатны хэсгээр болгоомжтой зорчих ба түлхэх, яаруулах, гүйх, гулсах үйлдэл хийж болохгүй. Өндөр хэсгийн хаалт хамгаалалтыг давж тонгойх, зүүгдэх, ирмэг дээр гарч зогсож болохгүй.
- 8. Ажлын байранд бага насны хүүхдээ авчирж болохгүй ба аргагүй тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг сайтар хангана, хүүхдийг үзвэрийн танхимд тоглуулах, шуугилдуулах, ноцолдох, тайз, яаман дээр гаргахыг хатуу хориглоно.
- 9. Ажлын байранд засварын ажил гүйцэтгэж байгаа үед болон тоног төхөөрөмжийг зөөвөрлөх, угсрах, буулгах ажлыг гүйцэтгэж байхдаа хөнгөн, нимгэн хувцаслахгүй байх, ажлын хувцас хэрэгслийг ашиглалтын зааврын дагуу өмссөн, хувийн бэлтгэлийг сайтар хангасан байна.
- 10. Албан хаагчид нь үйлдвэрлэлийн осол (*даатгуулагч ажил үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдах*), мэргэжлээс шалтгаалах өвчний (*даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчин*) даатгал, гэнэтийн ослын даатгалд даатгуулж тэтгэвэр, тэтгэмж авах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- 11. Албан хаагчид тайзны соёлтой байх ба тайзны ард болон эргэн тойрны зай талбайд зөвшөөрөлгүй орж болохгүй. Тайз, түүний эргэн тойронд тухайн үйл ажиллагаатай холбоотой албан хаагч л байна.

**Зургаа. Уран бүтээлчид, техникийн ажилтны аюулгүй ажиллагааны шаардлагууд**

Тус театрын албан хаагчид нь мэргэжлийн сургуулийг аюулгүй ажиллагааны арга барилыг бүрэн эзэмшиж төгссөн болзошгүй аюул ослоос өөрийгөө хамгаалах ур чадвартай мэргэжлийн албан хаагчид байна.

- 1. Уран бүтээлийн бэлтгэл ажлын зохих шатуудыг дамжин батлагдсан номер, тоглолт үзүүлбэрээ хийх итгэл төгс эрүүл мэндийн хувьд хэвийн байгаа нөхцөлд тоглолтонд орно.
- 2. Тоглолт, сургуулилтын бэлтгэлийн үед хөгжим хэрэгсэл, техник аппаратурыг бэлдэх, байрлуулах, буулгах гэх мэт ажлуудыг гүйцэтгэгч хүмүүс нь ажлын аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.
- 3. Нүүр будалтыг 30 минутын өмнө будаж, тоглож дуусмагц зохих зааврын дагуу арилгана.
- 4. Уран бүтээлчид хүнд хэцүү, анхаарал их шаардах, хурдтай темптэй үзүүлбэрийг бие бүрэн халах буюу тоглолтын төгсгөлд гүйцэтгэнэ.
- 5. Эргэж хөдөлдөг, юманд өлгөж болон холбож байрлуулдаг аппарат хэрэгслийн бэхэлгээг тайзны албан хаагчид л хийж гүйцэтгэх ба тэд доргилт даяалал болон бусад хүчин зүйлүүдийг нарийн тооцож тусгасан байвал зохино. Тоглолтын өмнө тайз, үзэгчдийн хэсгийн аппарат хэрэгслийн бүрэн бүтэн байдал, бэхэлгээ, хэвийн ажиллагаа, цэвэрлэгээ зэргийг шалгаж тусгай батлагдсан маяганд тэмдэглэл хийсэн байна.
- 6. Ажлын багаж, хувцас, хэрэгсэл зэргийн цэвэрлэгээ үйлчилгээнд шатах шингэн ашиглаагүй байна.
- 7. Чийгтэй нойтон шалан дээр алхах, бэлтгэл сургуулилт хийх, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийн байршуулж болохгүй.
- 8. Гэрэл, техник, аппаратурыг өргөх, буулгах, бэхлэх үед эгц доор нь зогсож болохгүй. Зөөврийн цахилгаан хэрэгсэл ашиглахдаа хүчдэл байгаа эсэх, газардуулга, тусгаарлагч байгааг магадлан шалгасан байна.

9. Бэлтгэл сургуулилт, бусад ажил үүргээ хийж гүйцэтгэж байхдаа ярих болон бусад байдлаар хамтрагчийнхаа анхаарлыг сарниулах аливаа үйлдэл хийхгүй байхаар сахилга баттай хариуцлагатай ажиллаж сурсан байна.
10. Нэг номерын сургууль хийж байх үед өөр номер зэрэгцэн сургуулих, өөр төрлийн ажил ажлын байранд болон тайзан дээр хийж гүйцэтгэж болохгүй.
11. Тоглолт сургуулилтын цагийн нягтрал болон хүнд үзүүлбэр тоглолтоос бие бялдрын их ачаалалтай уран бүтээлч нь эмчийн хяналтаас гадна өөртөө өдөр бүр хяналт тавьж биеийн байдлын хэлбэлзлийг мэдэрч бие бялдрын ачааллыг тохируулан хэт ядрах, их хүч алдахаас өөрийгөө хамгаалах үүрэгтэй.
12. Олон хүнтэй номерын сургуулилт, тоглолтонд уран бүтээлч нэг бүр өөрийн зорилго, зогсох байрлал тус бүрийнхээ үүргийг нарийн мэдэж бусдад найдалгүйгээр хамгаалах үүргээ ганцаарчлан гүйцэтгэнэ.

### **Долоо. Сургуулилт, тоглолтын цаг**

1. Уран бүтээлчийн бие бялдрын ачааллын байдлыг харгалзан бэлтгэл сургуулилт ба тоглолтын хооронд гурваас доошгүй цагаар, хоёр тоглолтын хооронд хоёр цаг хагасаас багагүй хугацаагаар, оройн тололтоос өглөөний тоглолт хүртэл 10-аас доошгүй цаг тус тус завсарлана.
2. Гэмтэл авах, өвчлөх зэрэг ямар нэг шалтгаанаар 1 сараас дээш хугацаагаар тоглолтонд ороогүй биеийн хүч ихээр шаарддаг үзүүлбэр үзүүлдэг уран бүтээлчид дадлага сургуулилтын тусгай цаг гаргаж өгнө. Сургуулийн хугацаа дуусч тоглолтонд оролцох зөвшөөрлийг эмчийн магадлагааг үндэслэн туслах найруулагч, уран сайхны удирдагч олгоно.
3. Эмэгтэй албан хаагчдын сарын тэмдгийн үед биеийн хүчний хүнд ачаалал шаардах сургуулилт, ажлаас чөлөөлж зөвхөн ачаалал бага шаардах ажил хийлгэхийг зөвшөөрнө, шаардлагатай тохиолдолд 1 хоног цалинтай чөлөө олгоно.

### **Найм.Бие халаалт**

1. Уран бүтээлчид нь өдөр бүр нийтийн буюу тусгай бие халаалтын дасгалд цаг гаргаж зохих дараалал баримтлан заавал хийнэ. Нийтийн болон тусгай биеийн дасгал нь 15 минутаас багагүй байвал зохино.
2. Бүжигчид ямар ч үед хөлс гартал биеийн дасгал хийнэ. Бие халаалтыг түргэтгэх зорилгоор биеийн тамирын ноосон цамц, өмдтэй дасгал хийвэл зохино. Хүйтэн байранд хийх дасгалын цаг удаан байх ба харин халуун чийгтэй байранд түргэн халдаг учир богиносгож болно.
3. Бие халаалтыг тоглолтоос 10-15 минутын өмнө дуусгасан байна. Энэ хооронд тоглолтын хувцсаа өмсөх, өөртөө зөөлөн иллэг хийх, амьсгалаа тайван байдалд оруулах, амрах зэрэг үйлдлийг хийнэ. Завсарлагааны үеэр биеийн температур багасахаас сэргийлж дулаан хувцас өмсөх, хүйтэн байвал дулаан байранд амарна.

### **Ес. Аппарат хэрэгсэл**

Аппарат хэрэгслийн онцлог эд ангиуд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эрэг холбоос цэвэрхэн, эрэг бүтэн өөрөө сулрахгүй байх
- Гагнаас холбоос нь зай завсаргүй, ан цавгүй, сайн гагнагдсан байх
- Цутгамал эд ангиуд хурц ирмэггүй, ан цавгүй, гадаргуу нь цэвэр өнгөлөгдсөн байх
- Ачаа өргөх эд анги төхөөрөмжүүд нь чанарын болон даацын тодорхойлолттой

байх

- Бүгд паспорттой байх, техникийн үзлэгийг тотмол хийж тэмдэглэл хөтөлдөг байх

1. Аппарат хэрэгслийг ашиглах байдлаар сургуулийн, туршилтын, ажлын гэж ангилна. Онц чухал хамгаалах элемент /тросс, штанг/-ийг зэвэрдэггүй ган буюу түүнээс илүү металлаар хийж зэврэлтээс хамгаалах бүрхүүл хэрэглэнэ. Троссын даацыг шалгахдаа ачааллыг 70%

- ихэсгэн тооцож сонгон авна. Олс нь тусгай зориулалтын уулынхан болон шүхэрчид хэрэглэдэг болн түүнээс сайн чанарын олс байвал зохино.
- 2. Онц чухал эд ангийн цахилгаан ба гагнуурыг зөвхөн мэргэжлийн гагнуурчнаар гүйцэтгүүлнэ. Тухайн аппарат хэрэгслийн техникийн паспортанд нийлүүлэгчийн нэр болон ажил биечлэн гүйцэтгэгч нарын мэдээлэл, гагнуурчны мэдээлэл, тэдгээрт ажиллах эрх, үзэмлэх олгосон байгууллагыг заавал тэмдэглэнэ. Онц чухал эд ангийг гагнаж засварлан торгоох төдий үйл ажиллагаатайгаар ашиглаж болохгүй, зориулалтын бус эд ангийг сольж хэрэглэхийг хориглоно.
- 3. Хөл гараар тулах байранд лент зөөлөн эдээр орооно.
- 4. Гэрэл, аппаратын эд ангиудад харилцан хөдөлгөөн нь тусгайлан заагаагүй бол илүү хольхилт байхгүй байвал зохино. Том овортой нь задардаг эвхэгддэг хийцтэй байвал тохиромжтой.
- 5. Аппарат хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвхөн зориулалтын талбайд нь стандартын дагуу бэхэлж байршуулсан байх ба хяналтгүйгээр нэмэлт төхөөрөмж байршуулах, цэвэрлэгээ үйлчилгээ, салгаж угсрах, бусад хэрэгслийг байршуулж ашиглахыг хориглоно.
- 6. Аппарат хэрэгслийн үзлэгийн үед эд анги нэг бүрийн чанар, бүрэн бүтэн байдал, боолт, давхар эрэг, холбоос нэг бүрийг сайтар гүйцэд шалгаж тэмдэглэл хөтөлнө.
- 7. Ажлын байр болон тайзны шал нь тэгш гадаргуутай хуучирч муудаагүй, эрэг боолт цухуйгаагүй, нүхгүй байна.
- 8. Бүх аппарат хэрэгслийг үйл ажиллагааны өмнө хуурай алчуураар арчиж цэвэрлэсэн байна.
- 9. Тайзны хөшиг, бусад даавуун хэрэгсэл нь тоосжилтгүй, шатахаас сэргийлэгдсэн байна. Дулаан, чийгний хяналттай, болзошгүй гамшгаас сэргийлэгдсэн стандарт хангасан талбайд хадгалагдана.
- 10. Аппарат хэрэгслийг эргүүлэх, өргөх, буулгах, тогтоох ажлыг цахилгаан хөдөлгүүрээр хийж гүйцэтгэнэ. Хөдөлгүүр гэмтэлтэй үед албан хаагчид гараар тухайн ажлыг хийж гүйцэтгэж болохгүй. Өөрийн чадлаас хэтэрсэн хүнд зүйлтэй харьцах, заавал бусад хүмүүстэй хамтран хийж гүйцэтгэх ажлыг бие даан ганцаараа хийж гүйцэтгэхээр зүтгэж болохгүй.
- 12. Цахилгаан тоног төхөөрөмжийн тэжээлийг тусгай зориулалтын шийднээс авах ба шийдний гадна талд хамгаалалт хийсэн байна. Үйл ажиллагааны явцад цахилгаан тоног төхөөрөмжүүдэд ямар нэг гэмтэл илэрвэл цахилгаан тэжээл, усан хангамж зэргийг тасалж цахилгаанчид мэдэгдэж яаралтай арга хэмжээ авна.
- 13. Албан хаагч нь өндөрт хамгаалалтын бүс, олсыг заавал зүүж ажиллана. Олс, хамгаалалтын бүсний гогцоо арал нь бүсэндээ болон таазанд найдвартай бэхэлгээтэй байх ба түүний хяналтыг тогтмол хийсэн байна.
- 14. Гарын алганы арьсыг өвчлөх тасрахаас мөн аппарат хэрэгслийг алдаж гэмтэхээс сэргийлэн гулгамтгай болон ширүүн аппарат хэрэгсэлтэй ажиллахдаа ажлын бээлийн заавал өмсөнө. Ажлын бээлийгээр тогтмол хангах, ашиглалтанд хянах тавих ажлыг санхүүгийн томилогдсон ажилтан хяналт тавьж бүртгэж ажиллана.
- 15. Аппарат хэрэгслийг өргөж буулгах үед доогуур нь хүмүүс байхыг хориглоно.
- 16. Албан хаагч нэг бүр өөрийн ашиглаж буй компьютер, хөгжим, аппарат, тоног төхөөрөмжөө аюулгүйн техникийн дагуу заавал шалгуулж баталгаажуулсан байна, өдөр дутам шалгана.
- 17. Акталсан аппарат хэрэгслийг ашиглахыг хориглоно.
- 18. Аппарат хэрэгслийн бэхэлгээний байр нь хүрч ашиглахад эвтэйхэн, үзэгчид хүрэхээргүй найдвартай байна.
- 19. Үйл ажиллагаа нэг бүрийн өмнө бүхий л аппарат хэрэгслийн байрлалт, бэхэлгээ, засалт, үзэгчдийн суудал, яам, хамгаалах хэрэгсэл зэргийг шалгаж цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд үзлэг хийж байвал зохино.

20. Гэмтэл зөрчилтэй аппарат тоног төхөөрөмж, ажлын талбай зэргийг бусдаас тусгаарлах ба ослын тэмдэглэгээ, плакат тогтоож бусдад хор учруулахаас сэргийлнэ.

Дээрх бүх ажилбарууд болон аппарат, хамгаалах хэрэгслийг зүүх, дүүжлэх, тогтоох бэхлэх, хайрцаглах, зөөвөрлөх, задлах, угсрах ажлыг тайзны ахлах мэргэжилтэн болон түүний томилсон албан хаагчийн хяналтан доор хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай хэрэгслийн талаархи мэдээллийг тухай бүрт нь удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх ажлыг тайзны ахлах мэргэжилтэн, туслах найруулагч нар хариуцан хийж гүйцэтгэнэ.

**Арав. Халаалт, агааржуулалт, осол**

1. Жилийн хүйтэн улиралд ажлын байрыг усан халаалт ба агааржуулалтын системээр тоноглоно.
2. Агааржуулалтын систем нь 2 хэсгээс бүрдэнэ. Үлээх (халуун, хүйтэн), сорох (байрны бохир агаарыг сорж цэвэрлэх). Агааржуулах системийн агаар солих хэмжээний хамгийн бага температурын норм нь 18 градус байна. Үзэгчдийн танхимын агааржуулалтын системд тунадасны ус орохоос хамгаалж хаалт хийсэн байна. Агааржуулах системийн шуугиан нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч болохгүй.
3. Осол аваарын үед ажлын байранд утаа, хярвас үнэртэж байвал агааржуулагч асаах, цонх онгойлгох, тамхи татах, ил гал гаргахыг бүх албан хаагчдад хориглож зааварчилгааны дагуу аюулгүй газар очсон байна.
4. Ослын үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ба шаардлагатай бол түргэн тусламж дуудаж эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авна.
5. Гал гарсан үед галыг зориулалтын хороор унтрааж аюулгүй болгоно. Хэрэв гал томорч унтраах боломжгүй болвол барилгад байгаа бусад хүмүүст мэдээлж аюулгүй газар очиж 101-т дуудлага өгнө.
6. Үйл ажиллагааны явцад ажлын бүсэд их хэмжээний тос, ус зэргээр бохирдсон бол элс үнс гэх мэтийг асгаж шингээсний дараа цэвэрлэж кальцуулсан уусмалаар угааж хатаана.
7. Ажил дуусах үед хариуцаж байсан ажилтан нь дараагийн ажлын ахлагч болон хариуцсан ажилтанд хүлээлгэж өгөхдөө барилгын бүх хэсэгт үзлэг хийж шаардлагатай мэдээллийг амаар болон бичгээр өгч тэмдэглэл хөтөлнө.
8. Халуун хүйтэн усны крант, унтраалга, хатаагуур зэргийг ашиглахдаа хүчтэй эргүүлэх, цохих, нүдэх үйлдэл хийж болохгүй.
9. Гадны халдлага болон, ямар нэгэн бүлэг этгээд булаан эзлэх, түрэмгийлэх, дээрэмдэх, айлган сүрдүүлэх зорилгоор орж ирвэл эсэргүүцэл үзүүлж гэмтэл авч болохгүй. Гэмт этгээдийн шаардлагыг биелүүлж байх явцдаа тухайн хүний өндөр, дууны өнгө, царай зүс, содон шинж тэмдэг, үйл хөдлөл, харилцааны онцлог шинжүүдийг сайтар ажиглан цээжилж гарч явсны дараа тэмдэглэл, зураглал хийн өөрийн болон цагдаагийн байгууллагад шууд мэдээлнэ.

**11. Гэрэлтүүлэг**

1. Заал, оффис, тоглолт (жүжигчний аясыг дагуулах, тодруулах, янз бүрээр өөрчлөн тохируулах боломжтой), завсарлага, сургуулийн, жижүүрийн, аваарын (тоглолтын турш асаалттай байх дохионы гэрэл; заал, цайны газар, кофе шоп, өлгүүр фойе, шатны талбайгаас явах замыг гэрэлтүүлэх нүүлгэн зайлуулах гэрэл гэсэн 2 төрөлтэй), гадна дотор талын фойены, хөшигний арын, барилгын орчин тойрны хамгаалалтын гэрэлтүүлэг багтана.
2. Гэрэлтүүлэг нь хэвийн ажиллагаатай байх ёстой ба шатсан, гэмтсэн тохиолдолд тэр дор нь заавал сольж хэвийн ажиллагаатай байлгана, зөвшөөрөгдөх хэмжээнээс их болон бага байгаа тохиолдолд ашиглахгүй байж тохируулгыг хийнэ.
3. Ажлын байрны гэрэлтүүлэг нь хурц биш, гялбаа байхгүй, гэхдээ хэтэрхий бүүдгэр сүүмгэр үзэгдэх орчин хязгаарлагдмал харагдахаар биш тод харагдаж байхаар байрласан байна.



### 12. Ажлын байр

1. Уран бүтээлчдийн өрөө нь 3.25м<sup>2</sup>-аас багагүй талбай ноогдохоор нүүр будгийн ширээ, өлгүүр, сандал, ширээний гэрэл, уух усны сав, хогийн сав, хувцасны шүүгээ зэрэг байна. Эд зүйлс нь бат бөх, гэмтэлгүй, зай талбай нь хангалттай хэмжээнд байна.
2. Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээг өдөр дутам хийх ба эмх цэгц, цахилгаан галын аюулгүй байдлын хяналтыг хүн нэг бүр өдөр дутам хийж зөрчлийг удирдлагад танилцуулан арилгана.
3. Гадуур хувцас, малгай болон бусад зүйлийг тайлж хувцасны шүүгээнд хийнэ.
4. Бие засах газар орох бүрдээ гараа савандаж угаах ба ажлын хувцас хэрэглэл бохирдсон тухай бүр цэвэрлэж хэрэглэнэ.
5. Ажлын байр, хувцсандаа болон биендээ гэмтэл учруулж болохуйц зүү, хайч, хутга гэх мэт хурц үзүүртэй зүйл байлгаж болохгүй.
6. Ус халаагч, богино долгионы зуух ажлын байранд ашиглаж байгаа бол аюулгүй байдлыг хангаж цахилгааны гэмтэл, осол гарах нөхцлийг бүрдүүлж болохгүй, ашиглаагүй тохиолдолд залгуурыг салгасан байна. Нойтон, чийгтэй гараар цахилгааны утас, унтраалга, залгуурт хүрч болохгүй.
7. Ширээ сандал, хөгжим хэрэгсэл, бусад эд зүйлсийг цэвэрлэх, зөөвөрлөхдөө тэдгээрийн дээр байгаа зүйлсийг заавал авсан байна, давхарлаж зөөж болохгүй.
8. Оффисын ажилтан болон доор дурдсан эд зүйлсийг ашигладаг, үйл ажиллагаандаа хэрэглэдэг албан хаагч нэг бүр ажлын онцлогтойгоор холбоотойгоор үүсэж болох аюултай болон хортой дараах нөлөөллөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана. Үүнд:
  - Ажлын бүс дэх дуу шуугиан, тоосжилт,
  - Агаарын чийгшил, температурын өөрчлөлт, агааржуулалт, халаалт, гэрэлтүүлэг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэлбэлзэх,
  - Компьютер, хэвлэгч, хувилагч, гар утас болон бусад хэрэгслийн цахилгаан соронзон, хэт ягаан туяа,
  - Нуруулдагч, зүсэгч, хайч, шугам, ширээ, сандал, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжийн хурц ирмэг, ир,
  - Хаалга, цонх, гэрэл чийдэн, эд зүйлсийн буруу байрлал, хоорондын зай
  - Ажлын байрны хана, шал, эд зүйлсийн өнгө будаг
  - Цахилгаан хэлхээний хүчдэл ихсэж, хүний биед нөлөөлж болох үе
  - Ажлын байранд аюултай гэмт итгээдүүд нэвтрэх
  - Ажлын бүс дэх агаарын тоосжилт, бусад хортой, галын аюултай хүчин зүйл нэмэгдэх
  - Оюуны, сэтгэл мэдрэлийн болон биеийн хүчний ачаалал
9. Ажлын сандал нь бүрэн тохиргоо хийх боломжтой байх хэрэгтэй бөгөөд хөлөө зориулалтын тавиур дээр тавих нь нурууны эмгэгээс урьдчилан сэргийлнэ.
10. Хувилагч машиныг ажилтнуудаас аль болох зайтай, коридорт юмуу эсвэл ажлын байрны үүд хавьцаа байрлуулна.
11. Ажилтнууд нэг өрөөнд олноор суудаг бол нам дуугаар ярилцаж, их дуу чимээ гаргахгүй явах нь албан хаагчдын тохь тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. Их дуу чимээ гаргадаг тоног төхөөрөмжийг хол зайд хяналттай байрлуулна.
12. Хэвлэгч хувилагчийн хор тонерыг ажлын өрөөндөө солих, сэгсэрч болохгүй ба энэ нь амьгалын замын эрхтэн системийг гэмтүүлдэг тул сэргийлж ажиллана.
13. Бичгийн цаас, баримт бичгийн хавтас, архивлалттай ажилладаг албан хаагчид ажлын байрны стандартыг мөрдөж ажиллах ба тоос тоосонцроос болгоомжилж ажлын үеэр халуун бүлээн сүү уух, витаминлаг хоол хүнс идэх, цэвэр агаарт гарах, тодорхой цагт завсарлаж дасгал хөдөлгөөн хийж эрүүл мэндээ хамгаална.

14. Компьютер дээр тасралтгүй юм шивэх тохиолдолд 1 цаг дутамд 5 минут гараа амраана, дэлгэцийг тасралтгүй ширтэж харааны эрхтэнг гэмтээж болохгүй ба асуудал үүссэн бол өөр ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Харааны эрхтэн гэмтэхээс урьдчилан сэргийлж чадахуйц мэдээ мэдээлэлтэй байна. Гэрэл дэлгэц дээр ойж ажиллахад хүндрэл үүсвэл цонхны хөшгийг буулгаж болно.

15. Компьютер дээр ажиллахдаа бугуй чөлөөтэй хөдөлж болохоор байлгана.

16. Ажлаа зөвхөн зөвшөөрөгдсөн зам гарцын дагуу явж гүйцэтгэх ба зам гарц, аваарын гарцыг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд, хайрцаг, сав суулга гэх мэт зүйлүүдээр хааж таглаж болохгүй.

17. Ажлын байран дээр зориулалтын бус зүйл дээр суухыг хориглоно.

### 13. Эмнэлгийн үзлэг, тусламж

1. Өвчтэй хүмүүсийг ажиллуулахыг хориглоно.

2. Ажилд орох болон ажиллах явцдаа жилд 1 удаа мэс засал, дотор, нүд, чих хамар хоолой, мэдрэл, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэгт нийт албан хаагчид орох ёстой.

3. Удаан хугацаагаар өвдсөний дараа буюу гэмтэл бэртэл авсны дараагаар ажиллах болсон албан хаагч нь дээрх хугацааг үл харгалзан эмнэлгийн үзлэгт орох үүрэгтэй.

4. Хөдөө орон нутагт ажиллах группт анхны тусламж үзүүлэх хүнийг сургаж бэлтгэнэ.

5. Хүнд, архаг өвчтэй, гэмтлийн үлдэцтэй албан хаагч нь хүнд ачаалал авах тоглолтонд орохыг хориглоно.

6. Уран бүтээлчдийн нүүрийн арьсан дээр шууд түрхдэг будгийн найрлагад /гялалзуулагч мөн орно/ арьсыг цочроох, өвчлүүлэх, хорт бодис, шар усны нүх бөглөх бодис орсон байж болохгүй. Уран бүтээлчид мэргэжлийн хяналтаар баталгаажсан бараа бүтээгдэхүүнийг худалдан авч зориулалтын дагуу хэрэглэх, нүүрний будаг, будаг арилгагч, хөвөн зэргийг сайн таглагдсан хайрцагт хадгалж гэмтэх, гадны халдлагад өртөхөөс сайтар сэргийлэх үүрэгтэй.

7. Тайз засах хэрэгсэл, жижиг хэрэгслийн тоос шороог хариуцсан ажилтан нь тоос сорогчоор соруулж болон чийгтэй алчуураар арчиж цэвэрлэсэн байна.

### 14. Хариуцлага

1. Улаанбаатар театрын нийт албан хаагчид нь тус дүрэмд заасан дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн албан хаагчид театрын дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

2. Энэхүү дүрмийг зөрчсөнөөс театрт эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.